

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны ...дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар.....

Журамд нэмэлт, өөрчлөлт  
оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Иргэний нисэхийн тухай хуулийн 6.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ НЬ:

1. Монгол Улсад 2023 онд хийгдсэн Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Нисэхийн аюулгүй байдлын аудитын тайлантай уялдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 136 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Иргэний нисэхийн аюулгүй байдлын журам”-д Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын Хавсралт 17-д заасны дагуу доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт тус тус нэмсүгэй:

1/Журмын 1.5.45 дахь заалт:

1.5.45.Нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээний байгууллага гэж иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээжсэн хуулийн этгээдийг.

2/Журмын 2.1.16 дахь заалт:

2.1.16.Энэ журмын шаардлагад нийцүүлж иргэний нисэхийн дүрэм, гүйцэтгэлийн шалгуур, заавар, журмыг боловсруулж, батлуулах.

3/Журмын 2.3.6 дахь заалт:

2.3.6.Гадаадын агаарын тээвэрлэгчийн төлөөлөгчийн газрын нэмэлт журмыг энэ журамд нийцүүлэн боловсруулж, батлуулах.

4/Журмын 2.5.6 дахь заалт:

2.5.6.Нисэх буудал, агаарын тээвэрлэгч, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллага болон бусад холбогдох байгууллагатай өөрсдийн үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийхэд ашиглах зохих мэдээллийг солилцох.

5/Журмын 2.8 дахь хэсэг, 2.8.1-2.8.7 дахь заалт:

2.8.Нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээний байгууллага нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.8.1.нисэх буудлын хориотой бүсэд нэвтрүүлэх худалдааны болон хангамжийн бараа, бүтээгдэхүүнд аюулгүй байдлын үзлэг хийх;

2.8.2.хориотой болон хамгаалагдсан бүсэд нэвтрэх үнэмлэх олгож, хяналт тавих;

2.8.3.нисэх буудлын хориотой бүсэд нэвтрэх хүмүүс, зорчигч, тэдгээрийн гар тээш, тээш болон ачаа, шуудангийн илгээмж, агаарын тээвэрлэгчийн шуудан болон эд зүйлст аюулгүй байдлын үзлэг хийх;

2.8.4.иргэний нисэхийн аюулгүй байдлын сургалтын хөтөлбөр, стандартын дагуу ажилтныг сургаж, дадлагажуулах;

2.8.5.аюулгүй байдлын үзлэгийг зөвхөн эрх бүхий этгээдээр гүйцэтгүүлэх;

2.8.6.нисэхийн аюулгүй байдлын дүрэм, журамд нийцсэн үйлчилгээ үзүүлэх;

2.8.7.нисэх буудлын хориотой бүсээр тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхдээ эрх бүхий байгууллагаас хийсэн эрсдэлийн үнэлгээг үндэслэн, эрсдэл тооцож шалгах.

6/Журмын 6.13.7 дахь заалт:

6.13.7.агаарын хөлгийн бүхээгт 2 болон түүнээс дээш тооны зэвсэгтэй ажилтан явах тохиолдолд бүхээгийн ажилтан тэдэнд суудлын байршлыг нь мэдэгдэх.

7/Журмын 6.25 дахь хэсэг:

6.25.Нисэх буудал нь эрх бүхий байгууллагын хийсэн эрсдэлийн үнэлгээг үндэслэн, эрсдэл тооцож, зорчигчийн гутлыг тайлуулж, рентген төхөөрөмжөөр шалгах.

8/Журмын 12.8 дахь хэсэг:

12.8.Ерөнхий газар нь хөндлөнгийн хууль бус үйлдэлд өртсөн агаарын хөлөг Монгол Улсын нутаг дэвсгэрт буусан тохиолдолд батлагдсан маягтын дагуу Олон улсын иргэний нисэхийн байгууллагад нэн даруй мэдэгдэх;

2. Журмын 4.21 дэх хэсэгт “Нисэх буудлын” гэсний өмнө “Нисэх буудал нь” гэж, 6.2 дахь хэсгийн “дараахь аргаар” гэсний дараа “эсхүл хослуулан” гэж, 6.5 дахь хэсгийн “дараахь аргаар” гэсний дараа “эсхүл хослуулан” гэж, 8.6 дахь хэсгийн “Өндөр эрсдэлтэй” гэсний өмнө “Нисэх буудал нь” гэж тус тус нэмсүгэй.

3. Мөн журмын дараах заалт, хэсгийг доор дурдсанаар тус тус өөрчлөн найруулсугай:

1/Журмын 3.11 дэх хэсэг:

3.11.Ерөнхий газар нь иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой баримт, мэдээллийг хамгаалах журамтай байна.

2/Журмын 4.17 дахь хэсэг:

4.17.Тээврийн хэрэгслийн нэвтрэх үнэмлэхэд дор дурдсан мэдээллийг тусгаж салхины шилний дотор талд ил харагдахаар, хөдөлгөөнгүй байрлуулна. Энэхүү үнэмлэхийн загварыг 2 жил тутамд шинэчлүүлнэ.

3/Журмын 8.5 дахь хэсэг:

8.5.Агаарын тээвэрлэгч нь агаарын хөлгөөр тээвэрлэхээр аюулгүй байдлын үзлэг хийсэн ачаа, шууданд агаарын хөлөг хөөрөх хүртэл байнгын хяналт тавина.

4/Журмын 13.3 дахь хэсэг:

13.3.Анкет шалгалтын мэдээллийг 2 жил тутам шалгаж, шинэчилнэ.

4. Журмын 2.8 дахь хэсгийг 2.9, 2.9 дэх хэсгийг 2.10, 2.10 дахь хэсгийг 2.11, 2.11 дэх хэсгийг 2.12, 2.12 дахь хэсгийг 2.13, 2.13 дахь хэсгийг 2.14, 2.14 дэх хэсгийг 2.15, 2.15 дахь хэсгийг 2.16, 2.16 дахь хэсгийг 2.17, 6.1 дэх хэсгийн “Нисэх буудлын эрх бүхий ажилтан” гэснийг “Нисэх буудал нь” гэж, 12.8 дахь хэсгийг 12.9, 12.9 дэх хэсгийг 12.10, 12.10 дахь хэсгийг 12.11, 12.11 дэх хэсгийг 12.12, 12.12 дахь хэсгийг 12.13 болгон тус тус өөрчилсүгэй.

5. Журмын 2.1.3 дахь заалтын “энэ журмын шаардлагад нийцсэн гадаадын агаарын тээвэрлэгчийн төлөөлөгчийн газрын нэмэлт журам” гэснийг хассугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

“Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”  
Засгийн газрын тогтоолын төслийн  
танилцуулга

2024 оны 10 дугаар сарын 14-ний өдөр

Улаанбаатар хот

Монгол Улс нь Чикаго хотноо 1944 онд батлагдсан Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцод 1989 онд нэгдэн орсноор тус конвенцын Хавсралт-17 “Иргэний нисэхийн аюулгүй байдал”-ын стандарт, шаардлагад нийцүүлэн нислэгийн аюулгүй ажиллагаа, түүний найдвартай, үр ашигтай байдлыг хангах дүрэм, журам, үйл ажиллагааны горимыг хэрэгжүүлэх замаар иргэний нисэхийн үйл ажиллагааг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах зорилго бүхий “Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулж, Засгийн газрын 2007 оны 175 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжүүлж ирсэн.

Дээрх хөтөлбөрийг 2007 онд батлан хэрэгжүүлж эхэлснээс хойш Хавсралт-17 “Иргэний нисэхийн аюулгүй байдал”-ын стандарт, шаардлагад орсон нэмэлт, өөрчлөлтүүдийг Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөрт тусган Засгийн газрын 2010 оны 164, 2015 оны 128, 2019 оны 13, 2020 оны 5 дугаар тогтоолоор тус тус батлуулсан.

Энэхүү үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлсэн 2007-2020 оны хооронд тус хөтөлбөрт нийт 4 удаагийн нэмэлт өөрчлөлт орж, 80-аас дээш хувь нь өөрчлөгдсөн. Мөн “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн нийцлийг харгалзан уг хөтөлбөрийг “Байнгын хэрэгжилттэй журмын шинжтэй байна” гэж үзсэн тул бүрэн шинэчлэн найруулж Засгийн газрын 2021 оны 136 дугаар тогтоолоор “Иргэний нисэхийн аюулгүй байдлын журам” болгон батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцын Хавсралт 17-д орсон 2022 оны 18 дахь нэмэлт, өөрчлөлтийн холбогдох стандарт, практик зөвлөмжүүдийг Иргэний нисэхийн аюулгүй байдлын журамд тусган нэмэлт, өөрчлөлтийг Засгийн газрын 2023 оны 339 дүгээр тогтоолоор батлуулсан.

Монгол Улс нь 2023 оны 10 дугаар сард Олон улсын иргэний нисэхийн байгууллагын нисэхийн аюулгүй байдлын аудитад шалгуулсан бөгөөд уг аудитаас өгсөн зөвлөмж, илэрсэн үл нийцлийг арилгах төлөвлөгөөний хүрээнд “Иргэний нисэхийн аюулгүй байдлын журам”-д тусгах нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулсан болно.

Энэхүү нэмэлт, өөрчлөлтийн төсөлд 2 хэсэг, 13 заалт шинээр нэмэх, 4 хэсэгт холбогдох үг нэмэхээр тусгаж, 4 хэсгийг өөрчлөн найруулж, 15 хэсгийн дугаар шилжүүлж, 1 заалт хасахаар тусгасан байна.

---оОо---

ИРГЭНИЙ НИСЭХИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЖУРМЫН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСӨЛД ШИНЭЭР ТУСГАХ БОЛОН  
ӨӨРЧЛӨН НАЙРУУЛАХ ХЭСЭГ БОЛОН ЗААЛТУУДЫН ҮНДЭСЛЭЛ

2024.10.14

Д/д	Заалтын дугаар	Нэмэлт, өөрчлөлт	Аудит шалгалтын үл нийцэл	Үндэслэл
<b>I. НЭМЭХ ХЭСЭГ, ЗААЛТ</b>				
1	1.5.45	Нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээний байгууллага гэж иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээжсэн хуулийн этгээдийг;	-	Журмын найруулга зүйн шаардлага
2	2.1.16.	Энэ журмын шаардлагад нийцүүлж иргэний нисэхийн дүрэм, гүйцэтгэлийн шалгуур, заавар, журмыг боловсруулж, батлуулах;	Finding No.01 Annex 17, SARP 2.1.2, 3.1.1	Хавсралт 17-ийн стандартад орсон нэмэлт өөрчлөлтийг хүлээн авмагц заасан хугацаанд Үндэсний эрх зүйн баримт бичиг, ИНБД-д нэмэлт өөрчлөлт оруулах журмыг хэрэгжүүлэх.  Хавсралт 17-ийн бүх стандартын дагуу ИНАБЖ-д холбогдох заалтуудыг тусгасан эсэхийг баталгаажуулах.
3	2.3.6	Гадаадын агаарын тээвэрлэгчийн төлөөлөгчийн газрын нэмэлт журмыг энэ журамд нийцүүлэн боловсруулж, батлуулах;	Finding No.25 Annex 17, SARP 3.3.2	Монгол Улс руу болон Монгол Улсаас нислэг үйлдэж байгаа гадаадын агаарын тээвэрлэгч нь ИНАБЖ-ын шаардлагыг хангасан Төлөөлөгчийн газрын нэмэлт журмыг боловсруулж, мөрдөж байгааг бататгах, хүчин төгөлдөр мөрдөж байгаа дүрэм, журмыг сайжруулах.
4	2.5.6	Нисэх буудал, агаарын тээвэрлэгч, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллага болон бусад холбогдох байгууллагатай өөрсдийн үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийхэд ашиглах зохих мэдээллийг солилцох;	Finding No. 03 Annex 17, SARP 3.1.5	Нисэх буудал, агаарын тээвэрлэгч, НХҮБ болон бусад байгууллагуудыг өөрсдийн нисэхийн аюулгүй байдлын үйл ажиллагаандаа үр дүнтэй эрсдэлийн үнэлгээ хийхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор зохих мэдээллийг солилцох үүрэг хүлээсэн байгууллагыг тодорхойлох.
5	2.8	Нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээний байгууллага нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.Үүнд:  2.8.1. нисэх буудлын хориотой бүсэд нэвтрүүлэх худалдааны болон	Finding No.19 Annex 17, SARP 3.5.2	Нисэхийн аюулгүй байдлын үзлэг шалгалт хийдэг ажилтан, нисэх буудлын хориотой бүсэд дагалдах хүнгүйгээр нэвтрэх эрхтэй ажилтан, нисэхийн аюулгүй байдлын эмзэг мэдээлэлд нэвтрэх ажилтанд тавигдах анкет шалгалтын шаардлагад тэнцэхгүй байх шалгуур, бүртгэл хадгалалтын

		<p>хангамжийн бараа, бүтээгдэхүүнд аюулгүй байдлын үзлэг хийх;</p> <p>2.8.2.хориотой болон хамгаалагдсан бүсэд нэвтрэх үнэмлэх олгож, хяналт тавих;</p> <p>2.8.3.нисэх буудлын хориотой бүсэд нэвтрэх хүмүүс, зорчигч, тэдгээрийн гар тээш, тээш болон ачаа, шуудангийн илгээмж, агаарын тээвэрлэгчийн шуудан болон эд зүйлст аюулгүй байдлын үзлэг хийх;</p> <p>2.8.4.иргэний нисэхийн аюулгүй байдлын сургалтын хөтөлбөр, стандартын дагуу ажилтныг сургаж, дадлагажуулах;</p> <p>2.8.5.аюулгүй байдлын үзлэгийг зөвхөн эрх бүхий этгээдээр гүйцэтгүүлэх;</p> <p>2.8.6.нисэхийн аюулгүй байдлын дүрэм, журамд нийцсэн үйлчилгээ үзүүлэх;</p> <p>2.8.7.нисэх буудлын хориотой бүсээр тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхдээ эрх бүхий байгууллагаас хийсэн эрсдэлийн үнэлгээг үндэслэн, эрсдэл тооцож шалгах;</p>	<p>Finding No.22 Annex 17, SARP 4.2.7</p>	<p>шаардлага орсон эсэхийг дахин нягтлах.</p> <p>Нисэх буудлын хориотой бүсэд нэвтрэхийг зөвшөөрсөн тээврийн хэрэгсэлд авах нисэхийн аюулгүй байдлын арга хэмжээний журам нь үндэсний холбогдох эрх бүхий байгууллагаас хийсэн эрсдэлийн үнэлгээний дагуу боловсруулагдсан эсэх мөн бүх тээврийн хэрэгслийг шалгах шаардлага тусгагдсан эсэхийг бататгах.</p>
6	6.13.7	<p>Агаарын хөлгийн бүхээгт 2 болон түүнээс дээш тооны зэвсэгтэй ажилтан явах тохиолдолд бүхээгийн ажилтан тэдэнд суудлын байршлыг нь мэдэгдэх;</p>	<p>Finding No.32 Annex 17, SARP 4.7.8</p>	<p>Хэрэв агаарын хөлгийн бүхээгт зэвсэгтэй этгээд нэгээс илүү зорчих бол зэвсэгтэй хүн бүрт нөгөө зэвсэгтэй этгээдийн суудлын дугаарыг мэдэгдэх талаар шаардлагыг боловсруулах.</p> <p>Нисэх буудлын түвшний холбогдох байгууллагууд агаарын хөлгийн бүхээгт зэвсэгтэй этгээд нэгээс илүү зорчих тохиолдолд тэдгээр зэвсэгтэй этгээд бүрт нөгөө зэвсэгтэй этгээдийн суудлын дугаарыг мэдэгдэх талаар журам боловсруулсан эсэхийг бататгах.</p>
7	6.25	<p>Нисэх буудал нь эрх бүхий</p>	<p>Finding No.27</p>	<p>Агаарын хөлгийн аюулгүй байдлын үзлэг болон</p>

		байгууллагын хийсэн эрсдэлийн үнэлгээг үндэслэн, эрсдэл тооцож, зорчигчийн гутлыг тайлуулж, рентген төхөөрөмжөөр шалгах;	Annex 17, SARP 4.3.1	шалгалтыг үндэсний эрх бүхий холбогдох байгууллагаас хийсэн эрсдэлийн үнэлгээнд үндэслэн хийгдэж байгаа эсэхийг тодорхойлж бататгах.
8	12.8.	Ерөнхий газар нь хөндлөнгийн хууль бус үйлдэлд өртсөн агаарын хөлөг Монгол Улсын нутаг дэвсгэрт буусан тохиолдолд батлагдсан маягтын дагуу Олон улсын иргэний нисэхийн байгууллагад нэн даруй мэдэгдэх;	Finding No.24 Annex 17, SARP 4.8.2	Болзошгүй хөндлөнгийн хууль бүс үйлдлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулахын тулд нийтийн эзэмшлийн бүсэд хэрэгжүүлэх аюулгүй байдлын арга хэмжээг тодорхойлохдоо эрсдэлийн үнэлгээ хийж байгааг бататгах.
9	4.21	“Нисэх буудлын” гэсний өмнө “Нисэх буудал нь” гэж	Finding No.26 Annex 17, SARP 4.24	Нисэх буудлын хориотой бүсэд байгаа агаарын хөлөгт зөвшөөрөлгүй нэвтрэх үйлдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор агаарын хөлгөөс болон агаарын хөлөг рүү чиглэлийн хүн ба тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих нэгж, байгууллагыг тодорхой болгох.
10	6.2, 6.5, 8.6	“дараахь аргаар” гэсний дараа “эсхүл хослуулан” гэж, 6.5 дахь хэсгийн “дараахь аргаар” гэсний дараа “эсхүл хослуулан” гэж, 8.6 дахь хэсгийн “Өндөр эрсдэлтэй” гэсний өмнө “Нисэх буудал нь” гэж нэмэх	-	Журмын найруулга зүйн шаардлага
<b>II. ӨӨРЧЛӨН НАЙРУУЛАХ ЗААЛТ</b>				
1	3.11.	Ерөнхий газар нь иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой баримт, мэдээллийг хамгаалах журамтай байна.	-	Журмын найруулга зүйн шаардлага
2	4.17	Тээврийн хэрэгслийн нэвтрэх үнэмлэхэд дор дурдсан мэдээллийг тусгаж салхины шилний дотор талд ил харагдахаар, хөдөлгөөнгүй байрлуулна. Энэхүү үнэмлэхийн загварыг 2 жил тутамд шинэчлүүлнэ.	Finding No.18 Annex 17, SARP 4.2.3	Нисэх буудлын ажилтнуудын болон тээврийн хэрэгслийн нэвтрэх зөвшөөрлийн журам нь байнгын шинжтэй, үр дүнтэй хэрэгжиж байгааг бататгах /НБ-ын ажилтан, тээврийн хэрэгслийн нэвтрэх зөвшөөрлийг ил харагдах байдлаар зүүх шаардлага/
3	8.5	Агаарын тээвэрлэгч нь агаарын хөлгөөр тээвэрлэхээр аюулгүй байдлын үзлэг хийсэн ачаа, шууданд агаарын хөлөг	Finding No.25 Annex 17, SARP 3.3.1	

		хөөрөх хүртэл байнгын хяналт тавина		
4	13.3	Анкет шалгалтын мэдээллийг 2 жил тутамд шалгаж, шинэчилнэ.	-	Анкет шалгалтын давтамжийг тодорхой зааж өгөх шаардлагатай.
5	2	Журмын 2.8 дахь хэсгийг 2.9, 2.9 дэх хэсгийг 2.10, 2.10 дахь хэсгийг 2.11, 2.11 дэх хэсгийг 2.12, 2.12 дахь хэсгийг 2.13, 2.13 дахь хэсгийг 2.14, 2.14 дэх хэсгийг 2.15, 2.15 дахь хэсгийг 2.16, 2.16 дахь хэсгийг 2.17 гэх	-	Журмын нэмэлт өөрчлөлтийн шинэчлэлээр дугаар шилжсэн.
6	6.1	6.1 дэх хэсгийн “Нисэх буудлын эрх бүхий ажилтан” гэснийг “Нисэх буудал нь” гэх	-	Найруулга засав.
7	12	12.8 дахь хэсгийг 12.9, 12.9 дэх хэсгийг 12.10, 12.10 дахь хэсгийг 12.11, 12.11 дэх хэсгийг 12.12, 12.12 дахь хэсгийг 12.13 болгон тус тус өөрчлөх	-	Журмын нэмэлт өөрчлөлтийн шинэчлэлээр дугаар шилжсэн
<b>III. ХАСАХ ЗААЛТ</b>				
1	2.1.3	Журмын 2.1.3 дахь заалтын “энэ журмын шаардлагад нийцсэн гадаадын агаарын тээвэрлэгчийн төлөөлөгчийн газрын нэмэлт журам” гэснийг хасах	-	Журмын 2.3.6-д найруулан тусгасан.